



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БУЯНТ-УХАА ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/19/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: С.Нацагдорж  
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn  
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ  
Утас: 261628 Цахим хаяг: bolorderned@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Эм Аудит ХХК  
Захирал: Ш.Сувдаа Цахим хаяг: smaudit97@gmail.com

Улаанбаатар хот  
2022 он

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	8
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	14
6. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ .....	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
8. Аудитын илрүүлэлт .....	15
8.2 Албан шаардлага .....	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандар
ИНҮТ	Иргэний нисэхийн үндэсний төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмад хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 071578

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БУЯНТ-УХАА ОЛОН УЛСЫН  
НИСЭХ БУУДЛЫН ДАРГА  
Л.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Буюнт ухаа олон улсын нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Буюнт ухаа олон улсын нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант онд нийт орлогыг 1,315.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 12,551.5 сая төгрөг, алдагдлыг 11,235.7 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр нийт 2,658.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 11,749.2 сая төгрөгийн зардал гарган, 9,090.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

### Бусад мэдээлэл

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,183,690,343.75	509,924,330.26
1.1.2	Дансны авлага	12,974,535,304.96	5,401,091,305.95
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,849,100,903.44	22,099,231.35
1.1.4	Бусад авлага	159,372,206.44	64,773,780.17
1.1.6	Бараа материал	632,035,458.84	419,015,159.53
1.1.10	Системийн авлага	4,610,549,374.38	1,909,632,686.69
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>21,409,283,591.81</b>	<b>8,326,536,493.95</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	52,069,523,128.30	47,661,338,813.81
1.2.2	Биет бус хөрөнгө	7,727,385.66	5,501,494.14
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	524,207,380.95	524,207,380.95
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>52,601,457,894.90</b>	<b>48,191,047,688.90</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>74,010,741,486.71</b>	<b>56,517,584,182.85</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	31,341,532.55	-
2.1.1.3	Татварын өр	1,200,541,356.23	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	122,700,376.43	6,911,152.52
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	161,570,951.80	11,223,600.00
2.1.1.12	Системийн өглөг	-	186,137,486.71
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,516,154,217.01</b>	<b>204,272,239.23</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	-	-
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,516,154,217.01</b>	<b>204,272,239.23</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>18,136,422,122.15</b>	<b>18,136,422,122.15</b>
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	18,136,422,122.15	18,136,422,122.15
2.3.8	Хойшлогдсон орлого	114,445,931.00	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	54,243,719,216.55	38,176,889,821.47
	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>72,494,587,269.70</b>	<b>56,313,311,943.62</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>74,010,741,486.71</b>	<b>56,517,584,182.85</b>

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	7,208,098,135.40	2,176,822,903.52
2	Борлуулалтын өртөг	19,077,378,759.85	10,649,264,158.83
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>(11,869,280,624.45)</b>	<b>(8,472,441,255.31)</b>
4	Түрээсийн орлого	1,149,900,413.40	155,977,126.27
5	Хүүний орлого	211,634,920.51	-
6	Бусад орлого	1,231,503,635.23	326,055,746.81
7	Борлуулалт маркетингийн зардал	-	-
8	Ерөнхий ба удирдлагын зардал	1,481,958,925.46	926,623,301.27
9	Санхүүгийн зардал	-	-
10	Бусад зардал	1,627,099,437.13	173,015,768.41
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	397,989,392.63	(256,277.14)
<b>12</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(11,987,310,625.27)</b>	<b>(9,090,303,729.05)</b>
13	Орлогын татварын зардал	-	-
<b>14</b>	<b>Татварын дараах ашиг ( алдагдал)</b>	<b>(11,987,310,625.27)</b>	<b>(9,090,303,729.05)</b>
<b>15</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>16</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(11,987,310,625.27)</b>	<b>(9,090,303,729.05)</b>
<b>17</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	<b>(11,987,310,625.27)</b>	<b>(9,090,303,729.05)</b>

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>		<b>18,136,422,122.15</b>	<b>132,871,931.00</b>	<b>67,066,471,119.82</b>	<b>85,335,765,172.97</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>18,136,422,122.15</b>	<b>132,871,931.00</b>	<b>67,066,471,119.82</b>	<b>85,335,765,172.97</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(11,987,310,625.27)	(11,987,310,625.27)
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	(18,426,000.00)	(835,441,278.00)	(853,867,278.00)
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>18,136,422,122.15</b>	<b>114,445,931.00</b>	<b>54,243,719,216.55</b>	<b>72,494,587,269.70</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>18,136,422,122.15</b>	<b>114,445,931.00</b>	<b>54,243,719,216.55</b>	<b>72,494,587,269.70</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(9,090,303,729.05)	(9,090,303,729.05)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	(114,445,931.00)	(6,976,525,666.03)	(7,090,971,597.03)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>18,136,422,122.15</b>	<b>-</b>	<b>38,176,889,821.47</b>	<b>56,313,311,943.62</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>24,596,541,958.48</b>	<b>7,737,234,250.00</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,004,781,739.97	1,373,769,562.84
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	36,531,743.00	66,329,927.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	5,512,400,000.00
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	16,555,228,475.51	784,734,760.16
1.1.6.1	Банк хоорондын гүйлгээ	3,569,844,090.64	721,717,158.47
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>37,626,769,562.98</b>	<b>8,399,835,263.49</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	11,345,057,788.15	4,528,708,928.62
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,196,900,000.00	1,479,774,896.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,380,843,473.34	315,505,463.02
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	923,181,324.11	516,145,202.14
1.2.5	Хүүний төлбөрт төлсөн	6,595,574.02	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	884,179,464.68	1,079,408,829.02
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	20,890,011,938.68	480,291,944.69
1.2.9.1	Банк хоорондын гүйлгээ	3,569,844,090.64	723,725,635.82
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(13,030,227,604.50)</b>	<b>(662,601,013.49)</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>211,634,920.51</b>	<b>-</b>
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	211,634,920.51	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-</b>	<b>11,165,000.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	11,165,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>211,634,920.51</b>	<b>(11,165,000.00)</b>
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>-</b>	<b>-</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-</b>	<b>-</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(12,818,592,684.00)</b>	<b>(673,766,013.49)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>14,002,283,027.75</b>	<b>1,183,690,343.75</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,183,690,343.75</b>	<b>509,924,330.26</b>



**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	гүйцэтгэл		
1	<b>НИЙН ОРЛОГО /ЦЭВЭР/</b>	<b>10,216,980.1</b>	<b>1,315,800.0</b>	<b>2,658,855.8</b>	<b>(1,343,055.8)</b>	202.1
2	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>10,655,625.3</b>	<b>1,315,800.0</b>	<b>2,815,039.5</b>	<b>(1,499,239.5)</b>	213.9
3	Буулт хөөрөлтийн орлого	3,890,997.9	558,000.0	1,241,138.5	<b>(683,138.5)</b>	222.4
4	Зорчигчийн хураамжийн орлого	2,231,288.0	282,000.0	262,982.0	<b>19,018.0</b>	93.3
5	Бусад орлого	4,533,339.5	475,800.0	1,310,919.0	<b>(835,119.0)</b>	275.5
6	Борлуулалтын хөнгөлөлт, буцаалт	438,645.2	-	156,183.7	-	-
7	<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>22,204,290.7</b>	-	<b>11,749,159.5</b>	-	-
8	<b>НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>18,162,456.3</b>	<b>12,551,501.9</b>	<b>8,243,287.8</b>	<b>4,308,214.1</b>	65.7
9	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>17,011,500.2</b>	<b>12,381,663.6</b>	<b>8,209,186.1</b>	<b>4,172,477.5</b>	66.3
10	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>11,661,118.3</b>	<b>7,656,436.2</b>	<b>5,482,380.0</b>	<b>2,174,056.2</b>	71.6
11	Үндсэн ба нэмэгдэл цалин	9,835,203.2	6,142,948.9	4,719,416.3	<b>1,423,532.6</b>	76.8
12	Унаа хоолны хөнгөлөлт	1,314,217.3	1,010,205.0	552,369.7	<b>457,835.3</b>	54.7
13	Гэрээт ажлын цалин	511,697.8	503,282.3	210,594.0	<b>292,688.3</b>	41.8
14	<b>Ажил олгогчоос төлөх НДШ</b>	<b>1,582,734.1</b>	<b>1,110,183.2</b>	<b>793,294.5</b>	<b>316,888.7</b>	71.5
15	Тэтгэврийн даатгал	1,003,793.0	727,361.4	521,622.7	<b>205,738.7</b>	71.7
16	Тэтгэмжийн даатгал	117,800.6	76,564.4	55,465.9	<b>21,098.4</b>	72.4
17	ҮОМШ-ийн даатгал	210,415.3	137,815.9	98,786.8	<b>39,029.1</b>	71.7
18	Ажилгүйдлийн даатгал	22,745.4	15,312.9	10,665.9	<b>4,647.0</b>	69.7
19	Эрүүл мэндийн даатгал	227,979.8	153,128.7	106,753.2	<b>46,375.5</b>	69.7
21	<b>Байр ашиглалттай холбоотой зардал</b>	<b>643,076.3</b>	<b>701,524.8</b>	<b>359,022.6</b>	<b>342,502.2</b>	51.2
22	Гэрэл, цахилгаан	411,384.5	453,438.6	206,481.5	<b>246,957.1</b>	45.5
23	Түлш, халаалт	187,983.4	202,512.3	131,991.7	<b>70,520.6</b>	65.2
24	Цэвэр, бохир ус	43,708.4	45,573.9	20,549.4	<b>25,024.5</b>	45.1
25	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>626,313.6</b>	<b>569,245.4</b>	<b>292,041.1</b>	<b>277,204.3</b>	51.3
26	Бичиг хэрэг	46,267.8	23,524.2	14,493.6	<b>9,030.6</b>	61.6
27	Тээвэр, шатахуун	384,735.2	328,500.0	181,767.7	<b>146,732.3</b>	55.3
28	Шуудан, холбоо, интернет	66,889.3	66,468.3	41,988.7	<b>24,479.6</b>	63.2
29	Хог хаягдал, цэвэрлэгээний зардал	126,569.8	127,894.6	47,273.5	<b>80,621.1</b>	37.0
30	БҮТЭЭ	1,851.5	22,858.3	6,517.7	<b>16,340.6</b>	28.5
31	<b>Нормативт зардал</b>	<b>293,284.3</b>	<b>30,435.0</b>	<b>2,280.0</b>	<b>28,155.0</b>	7.5
32	Нормын хувцас, зөөлөн эдлэл	293,284.3	30,435.0	2,280.0	<b>28,155.0</b>	7.5
33	<b>Эд, хогшил, урсгал засварын зардал</b>	<b>570,219.1</b>	<b>670,058.0</b>	<b>293,008.5</b>	<b>377,049.5</b>	43.7
34	<b>Багаж, техник хэрэгсэл</b>	<b>394,916.2</b>	<b>396,000.0</b>	<b>161,480.8</b>	<b>234,519.2</b>	40.8
36	Тоног төхөөрөмжийн	140,493.3	150,000.0	44,263.3	<b>105,736.7</b>	29.5

37	Автомашин	78,203.9	60,000.0	88,508.4	(28,508.4)	147.5
38	Аэродром	133,824.0	180,000.0	26,897.8	153,102.2	14.9
39	Гал унтраах зардал	2,959.4	6,000.0	1,811.3	4,188.7	30.2
40	<b>Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл</b>	<b>175,302.9</b>	<b>227,058.0</b>	<b>109,221.3</b>	<b>117,836.7</b>	48.1
41	<b>Урсгал засвар</b>	-	<b>47,000.0</b>	<b>22,306.4</b>	<b>24,693.6</b>	47.5
42	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,338,952.3</b>	<b>1,338,938.4</b>	<b>761,653.8</b>	<b>577,284.6</b>	56.9
43	Мэдээлэл сурталчилгааны зардал	5,946.0	6,000.0	88.0	5,912.0	1.5
44	Харуул хамгаалалтын зардал	4,984.4	8,560.0	2,180.6	6,379.4	25.5
45	Холбооны суваг ашигласны хөлс	272,346.1	271,814.4	137,716.5	134,097.9	50.7
46	Үл хөдлөх хөрөнгийн татвар	525,541.7	525,814.2	344,224.1	181,590.1	65.5
47	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	22,112.4	17,268.0	15,130.8	2,137.2	87.6
48	Мэдээлэл технологийн үйлчилгээ	9,889.8	7,841.4	12,797.5	(4,956.1)	163.2
49	Газрын төлбөр	484,723.5	484,723.5	242,361.7	242,361.8	50.0
50	Банк, санхүүгийн байгууллагын үйлч/хураамж	8,108.6	9,916.9	5,630.7	4,286.2	56.8
51	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,300.0	7,000.0	1,523.9	5,476.1	21.8
52	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>295,802.4</b>	<b>304,842.6</b>	<b>225,505.6</b>	<b>79,337.0</b>	74.0
53	Бараа үйлчилгээний бусад зардал	7,120.0	10,000.0	2,496.9	7,503.1	25.0
54	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	1,682.8	-	-	-	-
55	Түүхий эд материал	286,999.6	294,842.6	223,008.7	71,833.9	75.6
56	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,150,956.0</b>	<b>169,838.3</b>	<b>34,101.7</b>	<b>135,736.6</b>	20.1
57	<b>Гадаадын болон олон улсын гишүүний татвар</b>	<b>13,045.3</b>	<b>13,647.3</b>	<b>14,764.8</b>	<b>(1,117.5)</b>	108.2
58	<b>Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг</b>	<b>1,137,910.8</b>	<b>156,191.0</b>	<b>19,336.9</b>	<b>136,854.1</b>	12.4
59	Нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг	247,543.1	156,191.0	19,336.9	136,854.1	12.4
60	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	885,527.6	-	-	-	-
61	Шагнал, баяр ёслол	4,840.0	-	-	-	-
62	Төсөвт төвлөрүүлэх орлого	-	-	-	-	-
63	Валютин ханшийн зөрүү	17,853.6	-	256.3	-	-
64	Бараа, материал акталсны төлбөр	-	-	15,038.0	-	-
65	Түрээсийн орлогын төвлөрүүлэлт	314,032.8	-	79,526.5	-	-
66	Орлогын албан татвар	-	-	-	-	-
67	Үндсэн хөрөнгийн элэгдэл	3,644,981.2	-	3,408,825.0	-	-
68	Биет бус хөрөнгийн хорогдуулгын зардал	12,724.8	-	2,225.9	-	-
69	Харилцахын хүүгийн орлогын албан татвар	21,163.5	-	-	-	-
70	Систем хоорондын тооцоогоорх зардал	31,078.6	-	-	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 25-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Эс Эм аудит ХХК-ийн захирал Ш.Сувдаа хянан удирдаж, ахлах аудитор Ш.Эрдэнэчимэг, аудитор Д.Мягмаржаргал, Ж.Сайнтуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Чулуунбаатар хэрэгжүүлсэн.

Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 10/28-141 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

#### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 22,186.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 221.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 11,749.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 117.5 сая төгрөгөөр тогтоосон.

#### **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

##### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Буян-Ухаа олон улсын нисэх буудлын зорилго нь нисэх буудлын үйл ажиллагааг аюулгүй, шуурхай, соёлтой, үр ашигтай зохион байгуулж, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн цогц үйлчилгээг бүрдүүлсэн үндэсний шилдэг байгууллага болоход оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Монголын иргэний нисэхийн компаниудын болон улсын нислэгийн зорчигч тээврийн үйлчилгээний шуурхай ажиллагааг хангах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 2021 оны 8 дугаар сарын 02-ны өдөр хүртэл Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байсан, Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн А/276, А/277 тоот тушаалаар Буянт-Ухаа олон улсын нисэх буудлыг Иргэний нисэхийн үндэсний төвийн зохион байгуулалтын нэгжид хамруулан Аэродром, барилга байгууламжийн ашиглалтын алба, Буянт ухаа нисэх буудлын ашиглалтын хэсэг болгон хуваасан. Мөн Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/458 дугаар тушаалаар Иргэний нисэхийн үндэсний төвийн салбар Буянт ухаа олон улсын нисэх буудал болгон өөрчилсөн байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

##### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Буянт-Ухаа олон улсын нисэх буудал нь Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/458 тушаалаар Иргэний нисэхийн үндэсний төвийн салбар болсон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Буянт-Ухаа олон улсын нисэх буудал нь Төлөөлөн удирдах зөвлөлгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд жил бүр хагас жил, жилийн эцсээр хоёр удаа эд хөрөнгийн үзлэг тооллогыг зохион байгуулж үр дүнг өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцэж хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих арга хэмжээ авсан байна. Тайлант онд 2020 оны жилийн эцсийн тооллогын үр дүнгээс ТӨБЗГ-ын 2021 оны 325 дугаар тогтоолын дагуу нийт 145.3 сая төгрөгийн өртөгтэй элэгдлээ бүрэн нөхсөн 52 ширхэг үндсэн хөрөнгийг, 38.1 сая төгрөгийн өртөгтэй, элэгдлээ бүрэн нөхсөн 18 биет бус хөрөнгийг акталсан байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн

нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх"-д заасны дагуу 9 чиглэлээр 18 ажлын төлөвлөгөөг баталж, салбар нэгжүүд мөрдөж ажилласан. Тус төлөвлөгөөний хүрээнд батлагдсан төсөвт зардлаас тэвчиж болох зардлыг эрэмбэлэн хуваарилж, 8 дугаар сард ИНҮТ-д нэгдэх тул төсвийг эхний 8 сараар төлөвлөн 4,308.2 сая төгрөг буюу 34 хувийг хэмнэж ажилласан байна. Мөн шагнал урамшуулал, бүх төрлийн баяр ёслол, спортын арга хэмжээ зохион байгуулагдаагүй, зочин төлөөлөгч хүлээн авч бэлэг, дурсгал бэлдээгүй, сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж төлөвлөсөн зардлыг хэмнэсэн. Ажлын цагийн хуваарийг оновчтой зохион байгуулж, илүү цагаар ажиллуулахгүй байхаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 тоот тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”

#### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,183,690.3	509,924.3	(673,766.0)
Авлага	19,593,557.8	7,397,597.0	(12,195,960.8)
Бараа материал	632,035.5	419,015.2	(213,020.3)
Үндсэн хөрөнгө	52,069,523.1	47,661,338.8	(4,408,184.3)
Биет бус хөрөнгө	7,727.4	5,501.5	(2,225.9)
Хойшлогдсон татварын хөрөнгө	524,207.4	524,207.4	-
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>74,010,741.5</b>	<b>56,517,584.2</b>	<b>(17,493,157.3)</b>
Богино хугацаат өглөг	1,516,154.2	204,272.2	(1,311,882.0)
Эздийн өмч	72,494,587.3	56,313,311.9	(16,181,275.4)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>74,010,741.5</b>	<b>56,517,584.2</b>	<b>(17,493,157.3)</b>

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 509.9 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд ХХОАТ-ын авлага 3.3 сая суутган татварын авлага 0.3 сая, НӨАТ-ын авлага 5.2 сая, НДШ-ийн авлага 13.3 сая төгрөг байна.

Тайлант онд авлагын дансны үлдэгдэл 12,196.0 сая төгрөгөөр буурсан нь дотоодын авиа компаниас авах авлага 7,213.3 сая, гадаадын авиа компанийн захиалгат нислэгээс авах авлага 315.3 сая, бусад авлага 91.6 сая, системийн авлага 2,700.9 сая төгрөгөөр буурсан нь авлагын бууралтад голлон нөлөөлжээ.

2012 оноос хойш үүссэн МИАТ ТӨХК, Аэромонголиа ХХК, Хүннү эйр ХХК нараас авах үйлчилгээний төлбөр 16,359.4 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Засгийн газрын МИАТ ТӨХК-ийн талаар авах арга хэмжээний тухай 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 370 дугаар тогтоолоор МИАТ ТӨХК-ийн Буянт-Ухаа олон улсын нисэх буудалд ногдох 6,976.5 сая төгрөгийн авлагыг чөлөөлж данснаас хассан, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 10 дугаар сарын 15-ны 183/ШШ2021/02222 тоот “Зохигчдын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох” захирамжаар Аэромонголиа ХХК 1,577.9 сая төгрөгийн авлагыг Иргэний нисэхийн үндэсний төвд шилжүүлсэн байна. Хүннү эйр ХХК-ийн төлбөл зохих 4,124.8 сая төгрөг, Сентрал скуэр ХХК-ийн 6.1 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Худалдаа хөгжлийн банкны 21.7 сая төгрөгийн авлага талууд хооронд маргаантай байгаа тул шүүхэд нэхэмжлэл гаргахаар төлөвлөсөн, мөн Зэт 24 ХХК-ийн 2.9 сая төгрөгийн авлага байх бөгөөд тус байгууллагыг шүүхэд нэхэмжлэл гарган эрэн сурвалжилж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 419.0 сая төгрөг болж 213.0 сая төгрөгөөр буурсан нь 640.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 853.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Тайлант хугацаанд 10.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, дуусаагүй барилга, их засварын зардал 147.0 сая төгрөгөөр, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулсан 3.3 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2021 оны 325 дугаар тогтоолоор нийт 145.3 сая төгрөгийн өртөгтэй элэгдлээ бүрэн нөхсөн 52 ширхэг үндсэн хөрөнгө, 38.1 сая төгрөгийн өртөгтэй, элэгдлээ бүрэн нөхсөн 18 биет бус хөрөнгийг акталжээ.

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн А/202, 8 дугаар сарын 12-ны өдрийн А/298, 12 дугаар сарын 03-ны өдрийн А/457, 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А04 тоот тушаалуудаар 3,800.1 сая төгрөгийн өртөгтэй, 2,573.6 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг салбар хооронд балансаас баланст шилжүүлсэн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд системийн өглөг 186.1 сая төгрөг, 6.9 сая төгрөгийн урьдчилж орсон орлого, бусад богино хугацаат 11.2 сая төгрөгийн өр төлбөр байна. Үүнээс Худалдаа хөгжлийн банкны 5.0 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 10.4 сая төгрөгөөр буурсан нь Буянт-Ухаа олон улсын нисэх буудал 8 дугаар сард бүтцийн өөрчлөлт хийгдэн Иргэний нисэхийн үндэсний төвд нэгдсэн тул 1-8 дугаар сарын зардлын гүйцэтгэл гарснаас шалтгаалжээ.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Буян-Ухаа олон улсын нисэх буудлын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга 2021 оны Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын 2021 оны орлого зардлын төлөвлөгөөг тайлант оны нийт орлогыг 1,315.8 сая төгрөгөөр,

нийт зардлыг 12,551.5 сая төгрөгөөр, 11,235.7 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 2,658.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 11,749.2 сая төгрөгийн зардал гарган, 9,090.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2,658.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,343.0 сая төгрөг буюу 102 хувиар давсан нь Буянт-Ухаа олон улсын нисэх буудлыг 8 дугаар сард ИНҮТ-д нэгтгэхтэй холбоотой орлогын төлөвлөгөөг багаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 11,749.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 802.3 сая төгрөг буюу 6.4 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь эхний 8 сарын гүйцэтгэл бөгөөд жилийн төлөвлөгөөтэй харьцуулахад зардал хэтэрсэн байна.

Тайлант онд алдагдал 9,090.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,975.5 сая төгрөгөөр дутуу байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, НДШ-ийн зардлыг 2,519.2 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 342.5 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 277.2 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 377.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 577.3 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 79.3 сая төгрөг нийт 4,172.5 сая төгрөгийн хэмнэлттэй зарцуулагдсан нь нөлөөлж байна.

Тайлант онд хөрөнгө оруулалтаар ИНҮТ-өөс ухаалаг халдваргүйжүүлэлтийн хаалга 9.0 сая төгрөг, Аэровокзалын барилгын дээврийн их засварын ажилд 146.9 сая төгрөгийн хөрөнгийг Буянт-Ухаа олон улсын нисэх буудалд бэлтгэж үндсэн хөрөнгөнд шилжүүлсэн байна.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 16 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Буянт-Ухаа олон улсын нисэх буудал нь тайлант онд нийт 9,032.3 сая төгрөгийн 140 мэдээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас ил тод байршуулахаас 13.3 сая төгрөгийн 2 мэдээг байршуулаагүй, 1,041.2 сая төгрөгийн 3 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 86.7 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгснөөс, албан шаардлагын хэрэгжилт 50 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	86,700.0	1	86,700.0	1		50.0
Зөвлөмж	1		1		-		100.0
Нийт дүн	3	86,700.0	2		1		75.0

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг үнэн зөв, ил тод, хуулийн хугацаанд байршуулж, зөрчлийг арилгахаар хүргүүлсэн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна. Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны 3 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил давтан гарсан асуудалд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ажилтнуудын ээлжийн амралтын дундаж цалин хөлсийг тооцохдоо “Дундаж цалин хөлсийг тодорхойлох” журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа эсэхийг анхаарах.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 106.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 106.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 106.3 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 117.5 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 8.2 Албан шаардлага

1. Тайлант онд 291 ажилтны ээлжийн амралтын цалинг бодохдоо амралтын цалин бодох дундаж цалин хөлсөнд хоолны нөхөн олговрыг оруулж тооцоноос 74.2 сая төгрөгийн цалин илүү олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 “Ээлжийн амралтын олговрыг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлсний хэмжээгээр тогтооно.”, Дундаж цалин хөлс тодорхойлох журмын 4 дүгээр заалт "Ажилтанд олгож байгаа бүх төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого, /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй." гэж заасантай нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Цалин хөлсийг тооцохдоо холбогдох заавар, журмыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант хугацаанд 20 байгууллага, хувь хүнээс авах 27.1 сая төгрөгийн авлага, 1 байгууллагын 5.0 сая төгрөгийн өглөгийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэх.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Буянт-Ухаа олон улсын нисэх буудал	АХГ-2022/19/НА-СТА-ТӨА	Тайлант хугацаанд 291 ажилтны ээлжийн амралтын тооцоог бодож олгохдоо амралтын хоногт 74,184.0 мянган төгрөгийн хоолны нөхөн олговрыг тооцсон.	Амралтын хоногт олгосон хоолны нөхөн олговрыг нөхөн суутгах төлбөрийн акт	1	74,184.0						1	74,184.0			
2	Буянт-Ухаа олон улсын нисэх буудал	АХГ-2022/19/НА-СТА-ТӨА	Тайлант хугацаанд 20 байгууллага, хувь хүний 27,104.8 мянган төгрөгийн авлага, 2 байгууллагын 4,987.3 мянган төгрөгийн өглөгийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.	Харилцагч байгууллага, хувь хүнтэй тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах	1	32,092.1						1	32,092.1			
<b>ДҮН</b>					2	106,276.1						2	106,276.1			
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Буянт-Ухаа олон улсын нисэх буудал	АХГ-2022/19/НА-СТА-ТӨА	Шилэн дансны цахим хуудсанд 16 төрлийн 9,032,300.0 мянган төгрөгийн 140 мэдээ ил тод байршуулахаас 1,041,214.1 мянган төгрөгийн 3 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, мэдээллийг хуулийн хугацаанд ил тод байршуулах	1							1				
<b>ДҮН</b>					1							1				
<b>НИЙТ ДҮН</b>					3	106,276.1						3	106,276.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 475/2022-0458  
АХГ-2022/19/НА-СТД ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийт 291 ажилтанд ээлжийн амралт тооцож олгоходоо дундаж цалин хөлсөнд хоолны нөхөн олговор тооцсон дүнгээр ээлжийн амралтын цалинг тооцож олгосон зөрчилтэй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 55.2 "Ээлжийн амралтын олговрыг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлсний хэмжээгээр тогтооно.", Хөдөлмөр нийгмийн хамгаалалтын сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 4 дүгээр заалт "Ажилтанд олгож байгаа бүх төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого, лунаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дундаж цалин хөлс тодорхойлох журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын дарга Л.Отгонжаргал, нягтлан бодогч Ц.Цацрал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЭС ЭМ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Ш.СУВДАА

0001081308



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 473/20150 458  
АХГ 2022/15/НА-СТАТВА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 20 байгууллага, хувь хүний 27,104,780.01 төгрөгийн авлага, 1 байгууллагын 4,987,308.02 төгрөгийн өглөгийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харилцагч байгууллага, хувь хүнтэй авлага, өглөгийн тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын дарга Л.Отгонжаргал, нягтлан бодогч Ц.Цацрал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЭС ЭМ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Ш.СУВДАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

ХЭМЖЭЭГ 0 0315  
\*ХЭМЖЭЭГ 0 0315\* Bichig\_Khereg/Alban\_Shaardlaga/2022/0315\_Auditin\_2\_Gazar-150\_Docx

0001001284



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 472/20150458  
АХГ-2022/15/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 140 ажил, гүйлгээний мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 3 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг ил тод, хугацаанд нь байршуулж байх, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын дарга Л.Отгонжаргал, нягтлан бодогч Ц.Цацрал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЭС ЭМ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Ш.СУВДАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230



0001091392